

КЛИНИКИЙН НЭГДҮГЭЭР АМАРЖИХ ГАЗРЫН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Клиникийн Нэгдүгээр Амаржих Газрын буурал түүхийн шаргал хуудсанд нэрээ мөнхлөн үлдээж эх үрсийн эрүүл мэндийг хамгаалах нэр төртэй ариун үйлсэд хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн алтан гартай, алдар хүндтэй эмч нар, эх баригч, сувилагч, асрагч, эмнэлгийн нийт ажилтнууддаа болон энэ буянтай сайхан ууган амаржих газар анхны дуугаа хадааж мэндэлсэн нийт монголчууддаа таны унасан газар, угаасан ус, эх хүйн холбоотой төрөлх Нэгдүгээр Амаржих Газрын тань түүхт 85 жилийн ой 2013 онд тохиох гэж буйг утган мэндчилгээг өргөн дэвшүүлж байна.

Монгол Улсын 8 хүн тутмын нэг, Нийслэл Улаанбаатар хотын 3 хүн тутмын нэг нь 1-р амаржих газар мэндэлсэн нь манай эмч бурхад, хүйн ээж нарын нөр хичээнгүй хөдөлмөрийн ач буян билээ.

Тус амаржих газраас:

1. 1960 онд Нийслэлийн 2-р амаржих газар,
2. 1962 онд Цацраг туяа эмнэлэг
3. 1966 онд 3-р амаржих газар
4. 1987 онд Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Төв, ЭНЭШ – ний хүрээлэн салбарлан байгуулагдсан юм.

Манай хамт олны дундаас 85 жилийн хугацаанд Ардын эмч 1, МУ-ын Гавъяат эмч 13, 20 гаруй эрдэмтэн, 30 гаруй клиникийн профессор төрөн гарсан нь бид бүхний бахархал юм.

Энэ эрхэм ариун өргөөнд төрсөн хүн бүхэн эрдэм мэдлэг, оюун ухаан, эд баялаг төгс байж, урт удаан насалж, улс эх орондоо улам ихийг бүтээхийг хүсье!

Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах асуудал бол улс нийгмийн хүн амын төрөлт, өсөлт, үйлдвэрлэх хөгжлийн дэвшил хөгжлийн үндсийг бүрэлдүүлдэг нийгэм, улс төр, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий нийгэм- төрийн нэгдмэл арга хэмжээ юм. Энэхүү нэгдмэл арга хэмжээний эхлэл нь тус амаржих газрын түүхтэй холбоотой юм.

Монгол улсын 1928 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн Засгийн газрын эрхлэх товчооны гишүүдийн 59 дүгээр хурлын тогтоолоор тэр үеийн төв больниц, клиник эмнэлгийн дэргэд 3 сувилагчийн орон тоотой 6 ортой 900 төгрөгний төсөвтэй төрөх тасаг байгуулсан Улаанбаатар хотын КЛИНИКИЙН НЭГДҮГЭЭР АМАРЖИХ ГАЗРЫН үндэн суурь нь болжээ.

Таван жилийн дараа 1933 онд Төв больницын мэс заслын тасгийг түшиглүүлэн 10 ортой эмэгтэйчүүдийн тасгийг байгуулснаар эмэгтэйчүүдийн өвчний тусламжийг үзүүлэх болсон байна.

Энэ үед үндэсний боловсон хүчин хараахан бэлтгэж амжаагүй байсан учир ЗХУ-аас уригдаж ирсэн их бага эмч, эх баригч нар ажиллаж байлаа.

1. Төрөх тасгийн анхны их эмчээр Зөвлөлтийн эмч Надот ажиллаж байжээ.
2. 1935 онд эх барихын 30 ор
3. 1940 онд 40 ор, эмэгтэйчүүдийн 20 ор бүгд 90 ортой болж өргөжжээ.
4. 1947 оны 3 сараас МУИС-ын Анагаах ухааны факультетийн эх барихын тэнхим байгуулагдсанаар эмч, оюутны сургалтын бааз болж эхэлсэн бөгөөд ЗХУ-аас уригдаж ирсэн В.А.Анисимов анхны тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байжээ.



Анхны эмч нар

- 1949 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор эх барих эмэгтэйчүүдийн өвчнийг эмчлэх тасгийн бие даасан больниц болгох шийдвэр гарч анхны төрөх газарт зориулагдсан барилга барьж 1951 онд ашиглалтанд орж «Төв төрөх» нэртэйгээр нээгджээ.
- Төв төрөх газар 1951.5.4-ны өдөр анхны төрөх эхийг хүлээн авч төрүүлсэн ба энд төрөхийн 110 ор, эмэгтэйчүүдийн 40 ор, бүгд 150 ортой бие даасан төрөх газар болж байгуулагдсан байна. Энэ бол жинхэнэ төрөх газрын зураг тасвийн дагуу баригдсан анхны байшин төдийгүй, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийн төв анх нээгдсэн хэрэг юм.
- 1957 оноос тус төрөх газрын дэргэд эмэгтэйчүүдэд зөвөлгөө өгөх тасагтай болж өргөжсөн байна.
- Төрөх газрын дэргэд 1955 онд 100 ортой эмэгтэйчүүдийн тасгийг бие даасан больницын хэмжээнд байгуулан ажиллажээ. Одоо тус тасаг нь бүх төрлийн эмэгтэйчүүдийн өвчнийг эмчлэх мэс засал, эмчилгээний салбар тасгуудтай эмэгтэйчүүдийн өвчин судлалын орчин үеийн эмнэлэг оношлогооны аргуудыг нэвтрүүлэх гол төв болон улсын чанартай тусламжийг үзүүлж байна
- Тус амаржих газрыг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1967 оны 12 дугаар сарын 30-ны № 396 дугаар тогтоолын дагуу 1968 онд КЛИНИКИЙН АМАРЖИХ ГАЗАР болгон өргөтгөсөн байна.
- 1978 онд амаржих газрын 50 жилийн ойг тохиолдуулан тус газрыг «Алтан гадас» одонгоор шагнасан юм.
- Амаржих газрын материаллаг бааз жилээс жилд улам бэхжиж 1981 онд шинэ барилгын өргөтгөлийг хүлээн авч, улс хотын хэмжээнд эх барих эмэгтэйчүүдийн тусламжийг үзүүлдэг 405 ор бүхий нарийн мэргэжлийн төв болжээ.
- 1995 онд хүүхдэд ээлтэй эмнэлгийн болзолыг хангаж, гэрчилгээ авсны дээр эх нярайн эндэгдлийг гаргахгүйн төлөө эвсэг хамт олныг бүдүүлэн ажиллаж сүүлийн



жилүүдэд жирэмсний болон ургийн эмгэгийг оношлох, эмчлэхэд биомонитор, сальпингография зэрэг оношлогоо шинжилгээний аргыг нэвтрүүлэн ажиллаж байна.

13. Нийгмийн хөгжлийн түүхэнд 1990 оноос хойш эдийн засгийн уналт болон ардчилсан хувьсгалын дараа, төрөлт буурсан он жилүүд болох 1997 оноос эхлэн төрөх газрын анхны барилгыг Нийслэлийн өмчид шилжүүлсэнээр Сайд нарын тогтоолоор 405 орны тоог багасгаж 240 ортой болгож эмнэлгийн дэргэдэх амбулаторийн тусламжийг өрх дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд шилжүүлсэн байна.
14. Ийнхүү 1997 оны 5 дугаар сараас 2012 оны хооронд ЭМНХЯ-ны Сайдын А/87 тоот тушаал, Нийслэлийн засаг даргын 5/100 дугаар захирамжийн дагуу 250 ортой, 248 ажилтантай 192.5 сая төгрөгний төсөвтэй, 7 тасагтай ажиллаж байв
15. 2010 оны 09 сарын 28 ны өдрийн 46 тоот тогтоолоор MNS 6164:2010 «Эрүүл мэндийн технологи, Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа» стандарт батлагдан гарсанаас хойш 2011 оноос эхлэн Клиникийн Нэгдүгээр Амаржих Газар нь 12 тасаг нэгжтэй 296 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.
16. 2000 онд эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резиденсийн сургалт эрхэлсэн Төгсөлтийн дараах сургалтын алба үүсгэн байгуулагдаад 1.5 жилийн хугацаанд эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмч бэлтгэх сургалтаар нийтдээ 131 эх барих эмэгтэйчүүдийн эмч төгсгөөд байна.
17. 2002 онд КНАГ нь магадлан итгэмжлэлийн шалгалтаар амжилттай дүн үзүүлж Эрүүл мэндийн тусламж үзүүлэх, үйл ажиллагааны стандартыг шаардлагыг хангасны учир магадлан итгэмжлэгдэж улмаар 2005 онд дахин 4 жилээр сунгагдсан юм.
18. Тус амаржих газар байгуулагдсан анхны өдрөөс эхлэн эх баригч, сувилагч нарыг бэлтгэдэг төв болсоор ирсэн бөгөөд 1935 онд Зөвлөлтийн мэргэжилтэн Чуловский 10 монгол эх барих сувилагчийг курсээр анх бэлтгэн аймгуудад явуулж,
19. 1939 онд эх баригчийг курсээр бэлтгэж байжээ.
20. 1957 оноос эх барих эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн 12 их эмчийг эх барих эмэгтэйчүүдийн тэнхимийн эрхлэгч В.С. Соловьевын удирдлаган дор бэлтгэн гаргаснаас хойш олон арван их эмчийг эх барих эмэгтэйчүүдийн мэргэжил олгох, дээшлүүлэх курс болон клиник ординатураар бэлтгэгддэг практикийн байгууллагын төв төдийгүй эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, эмч мэргэжилтний эрдэм шинжилгээ судалгааны, Анагаах ухааны дээд сургуулийн ахлах курсын оюутны сургалтын бааз клиникийн эмнэлэг болон өргөжжээ.



*М.Дамбадорж, Г.Цэвэлмаа, Д. Ичинхорлоо, Б.Жав, зөвлөх эмч Дуда И.В.
нарын эрдэмтэд*

21. Анх төрөх тасгийн эмч Надот эх барих эмэгтэйчүүдийн хичээлийг зааж эхлэн, тасгийн эрхлэгч Гринберг, эх барих эмэгтэйчүүдийн тэнхимийн эрхлэгч В.И. Анисимов, Е.К. Александров, А.А.Никольская , Б.С. Соловьев, П.С.Верноцкий нар ажиллаж байжээ.
22. Тус амаржих газар ажиллаж байсан хамт олны дотроос Д.Тамжав, Г.Дуламжав, Ц.Дэмид, Д.Цэвэлмаа, Б.Бадам, Б.Жав, Б.Үйлст, Б.Бүлтэн нар хүний гавьяат эмч, М. Дамбадорж гавьяат багш цолоор тус тус шагнагдаж, Б.Жав, Б. Лувсан-Ёндон, С.Дорж, Д. Ичинхорлоо, Д.Цэндсүрэн Д.Дариймаа, Д.Баттогтох, Ш.Цэрэнсамбуу, Г.Баясгалан, Ч.Мядаг, Т.Одбайгаль, А.Дүүрэнбилэг, С.Мөнхзул нар Анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.
23. Ч.Дариймаа, Б.Үйлст, Ч.Содномпил, Б. Бүлтэн, М.Энхтуяа, Д.Энхбаяр, Д.Оюунцэцэг, Б.Лхамаахүү, Н.Бадрах, Д.Өнөржаргал нар клиникийн профессор цол хүртсэн байна.

Клиникийн нэгдүгээр Амаржих газрын түүхэн замналд нөр их хөдөлмөрөө зориулсан ахмад үеийн алтан гартай эмч, эх баригч, сувилагч нар олон бий.

АХМАД ЭМЧ, АЖИЛЧИД, АЛДАРТНУУД



Төрөхийн анхны эмч нар




*Шоовдор, Даваахүү,
Баасанжав, Бумцэнд нарын
алдартнууд*



1951 онд төрөхийн барилга ашиглалтанд ороход төрсөн анхны нярай Баярмагнай



2007 он Баярмагнай эх баригч Юмжавын хамт



1949 он Тэр үед төрөхөөс өгдөг гэрчилгээ ийм байжээ




1946 оны 1-р сарын 10-нд төрсөн Биндэрьяа



7-р таван жилийн гавшгайчид



Хамгийн ахмад эх баригч, сувилагч нар



*Балган, М.Энхтуяа эмчтэй
хамт олон, 1980 аад он*



*М.Дамбадаржаа багш, Д.Авирмэд эмч
нарын хамт, 1985 он*



Б.Норпил, Д.Ичинхорлоо, Балган эмч нар хамт олонтойгоо, 1985 он



Б.Үйлст, А.Цогзол нартай хамт олон, 1998 он



Б.Бүлтэн эрхлэгчтэй хамт олон, 1986 он



Зөвлөх эмч Б.Үйлст, Тасгийн эрхлэгч Ш.Цэрэнсамбуу нартай хамт олон, 2008 он



Р.Даваахүү эрхлэгчтэй хамт олон, 1982 он



Ч.Одончимэг эрхлэгчтэй 2007 оны шилдэг хамт олон



Н.Нямаа эрхлэгчтэй онош зүйн тасгийн хамт олон, 1998 он



Ч.Содномпил эрхлэгчтэй тасгийн хамт олон, 1997, 2008 он



2008 он Ахмад сувилагч нар



2008 он Ахмад асрагч нар



2010 он Үе үеийн эмч нар



2010 он Үе үеийн эх баригч нар

МАНАЙ ҮЕ ҮЕИЙН ЕРӨНХИЙ ЭМЧ НАР

Анхлан 1950-1953 онд тус амаржихыг үүсгэн байгуулж ерөнхий эмчийн үүргийг Александров Евсей эмч гүйцэтгэж түүнтэй хамт МУГЭ Д.Цэвэлмаа, А.Дунгаамаа нар хамтран ажиллаж байжээ.



1980 – 1982 онд Амаржих газрын өргөтгөлийг барьж эх үрсийн төлөө ажил хөдөлмөрөө Ерөнхий эмч Т.Наваансамдан зориулж байжээ. Бидний ахамд эмч сурган хүмүүжүүлэгч нараас дурьдхад тус амаржих газартай нэр нь салшгүй холбоотой эмч нар олон бий: МУГЭ Б.Бадам, МУГЭ Ц.Дэмид, МУГЭ Б.Дуламжав, МУГЭ Д.Тамжав нар билээ.

Улмаар төрөхийн түүхэн хугацаанд Ерөнхий эмчээр дараах нэр төртэй эмч нар ажиллаж байжээ:

1. Ц.Дэжид 1951-1952
2. Г.Дуламжав 1952 -1953
3. Л.Дуламжав 1953 – 1962
4. С.Дулмаа 1962-1964
5. Б.Лувсан-Ёндон 1964-1965
6. Х.Бадарч 1965-1971
7. Д.Данзан 1971-1972
8. Б.Лувсан-Ёндон 1972-1975
9. С.Наваансамдан 1975-1976
10. Л.Мижиддорж 1976-1978
11. С.Наваансамдан 1978-1980
12. Д.Авирмэд 1980-1982
13. И.Бямбаа 1982-1984
14. Т.Эрхэмбаатар 1984-1987
15. Л.Мижиддорж 1987-1994
16. Ч.Дариймаа 1994-1998.04
17. С.Хишгээ 1998.04-1999
18. Ч.Дариймаа 1999-2007.09
19. С. Пүрэвсүх 2007. 09 – 2010. 01
20. Д. Энхбаяр 2010 оны 01 сараас одоог хүртэл ажиллаж байна.



Үе үеийн ерөнхий эмч нар хамт олонтойгоо 1996 он



ӨНӨӨДРИЙН КЛИНИКИЙН НЭГДҮГЭЭР АМАРЖИХ ГАЗАР

Эрхэм зорилго:

НҮЭМ-ийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, эх нялхсыг эсэн мэнд амаржуулж, эх эмэгтэйчүүдэд сэтгэл хангалуун байдлыг бий болгон тав тухтай орчинг бүрдүүлэх.

УРИА:

ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙ – ТА БИДНИЙ ГАРТ

Клиникийн Нэгдүгээр Амаржих Газар нь харьяалагдах дүүргийн болон Эрүүл Мэндийн Нэгдлээс илгээсэн Нөхөн үржихүйн насны эх, эмэгтэйчүүдийг хүлээн авч эх барих, эмэгтэйчүүдийн цогц тусламж үзүүлэх үүрэг бүхий эх нялхсын байгууллага юм.

КНАГ-ын зорилт нь Монгол Улсын Эрүүл Мэндийн багц хуулиуд, иргэний эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжуудын хүрээнд эх эмэгтэйчүүдэд нарийн мэргэжлийн тусламж үзүүлэн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар зөвлөмж өгч, эсэн мэнд амаржуулахад оршино.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дүүргүүдийн ЭМН, өрхийн эмнэлэг болон бусад адилтгах төрлийн эх нялхсын байгууллагуудтай ажил төрлийн уялдаа холбоотой ажилладаг юм.

Манай байгууллага нь чанартай үйлчилгээ, мэргэжлийн тусламжийн чанар, багаар ажиллах чадвар, олон нийтийн оролцоо, сургалт сурталчилгааны үйл ажиллагаагаараа үнэлэгддэг юм.

КНАГ-ын Ерөнхий эмчийн товч танилцуулга

1. ОВОГ НЭР:

Дондог Энхбаяр

2. ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ:

Амаржих газрын дарга, Ерөнхий эмч

3. БОЛОВСРОЛ:

- * 1986 онд АУДЭС төгссөн
- * 1987 онд Рентгений мэргэжил олгох курс
- * 1990 онд АУДЭС эхографийн мэргэжил олгох
- * 1999 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт
- * АНУ-н Томас Жефферсоны их сургууль, Тайландын Махидолын их сургууль, БНХАУ-ын Шанхай хотын Фуданы их сургуульд тус тус мэргэжил дээшлүүлсэн

4. АЖЛЫН ТУРШЛАГА:

- * 1986-1987 онд ЭАХНСУИнситут токсикологич эмч
- * 1987-1990 онд УКТЭ рентген их эмч
- * 1990-2002 онд УКТЭ тасгийн эрхлэгч, эхографийн их эмч
- * 2002-2005 онд УКТЭ дэд захирал
- * 2005-2010 онд НЗДТГазар Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- * 2010 оноос КНАГ-ын Дарга, Ерөнхий эмч

5. ЦОЛ: Клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч

Клиникийн Нэгдүгээр Амаржих Газрын хүний нөөцийн чадавхи

Нийт 296 орон тооны бүтэцтэйгээр ажиллаж байгаагаас суулийн 10 жилийн хугацаанд КНАГ-ын хүний нөөцийн чадавхи ихээр өсч нийтдээ 1 гавьт эмч, 9 клиникийн профессор, 7 АУ-ны доктор, 6 магистр, мэргэжлийн ахлах 32, тэргүүлэх зэрэгтэй 35 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.


АМАРЖИХ ГАЗРЫН АЛДАРТНУУД, ЗӨВЛӨХ ЭМЧ НАР



Б.Бүлтэн – МУГЭ,
Зөвлөх эмч,
Клиникийн
профессор



Ч.Содномпил
- Клиникийн
профессор, Алтан
гадас одонт



М.Энхтуяа - Зөвлөх
эмч, Клиникийн
профессор, Алтан
гадас одонт,



С.Баясгалан – Зөвлөх
эмч, Эмчилгээ эрхэлсэн
орлогч дарга



Н.Бадрах -
Клиникийн
профессор, Алтан
гадас одонт



Ч.Мядаг – АУ-ны
доктор, Зөвлөх эмч,
Алтан гадас одонт




А.Оюунцэцэг
- Алтан гадас
одонт

ХҮНИЙ НӨӨЦИЙН НЭМЭГДСЭН БАЙДАЛ

Мэргэжил	2009 он	2012 он
1 Нийт ажиллагсад	256	308
2 Эх барих эмэгтэйчүүдийн эмч	28	39
3 Нярайн эмч	6	8
4 Дотрын эмч	-	1
5 Чанарын албаны дарга	-	1
6 Эрүүл ахуйч халдвар судлагч их эмч	1	3
7 Халдвар хяналтын ажилтан	-	1
8 Эм шинжлэгч	-	1
9 Эх баригч бага эмч	25	29
10 Нярайн сувилагч	16	20
11 Лавлагааны сувилагч	-	2
12 Мэс заслын дараах хэсгийн сувилагч	-	4
13 Хөдөлмөр хамгааллын инженер	-	1

Нийт эмч нарын боловсролын чадавхи



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНҮҮДИЙН МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГЭЭР:

※ **Анагаах ухааны доктор - 7 буюу 11%**

- Г. Баясгалан- Сургалт, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны албаны дарга
- Ш. Цэрэнсамбуу- Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Ч.Мядаг – Жирэмсний эмгэгийг эмчлэх тасгийн эрхлэгч
- А.Дүүрэнбилэг- Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Т. Одбайгал - Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Д.Уранчимэг- Эх барих эмэгтэйчүүдийн эмч
- С.Мөнхзул - Эх барих эмэгтэйчүүдийн их эмч

※ **Клиникийн профессор - 10 буюу 15%**

- Д.Энхбаяр - Ерөнхий эмч
- Б.Бүлтэн – МУГЭ, Зөвлөх эмч
- С.Баясгалан - Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- Ч. Содномпил - Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний их эмч
- М.Энхтуяа - Зөвлөх эмч, Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Б.Лхамаахүү - Статистикч их эмч
- Д.Оюунцэцэг - Нярайн эмч
- Н.Бадрах – Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Д.Өнөржаргал - Эх барих эмэгтэйчүүдийн их эмч
- Б.Эрдэнэцэцэг – Нярайн эмч

※ **Удирдахуйн менежер – 9 буюу 13,6%**

- Д. Энхбаяр - Дарга, Ерөнхий эмч
- Г. Баясгалан - Сургалт, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны албаны дарга
- Ц.Мөнхцэцэг - Чанарын албаны дарга

Ж.Дэлгэрцэцэг - Хүний нөөцийн менежер

Ч. Мятаг - Жирэмсний эмгэгийг эмчлэх тасгийн эрхлэгч

Ш. Цэрэнсамбуу - Эх барих эмэгтэйчүүдийн их эмч

Д. Өнөржаргал - Эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч

П. Эрдэнэбаатар - Мэдээгүйжүүлэлт эрчимт эмчилгээний эмч

* **АУ-ны магистр - 16**

* **Докторант – 8**

* **Мэргэжлийн тэргүүлэх зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд - 35**

* **Мэргэжлийн ахлах зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд – 32**

ӨНӨӨГИЙН АМАРЖИХ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Манай байгууллага нь чанартай үйлчилгээ, мэргэжлийн тусламжийн чанар, багаар ажиллах чадвар, олон нийтийн оролцоо, сургалт сурталчилгааны үйл ажиллагаагаараа үнэлэгддэг юм.

КНАГ нь дараах зохион байгуулалтын бүтэцтэй:

- * Захиргааны хэсэг
- * Аж ахуйн тасаг
- * Эмнэлэг үйлчилгээний хэсэг
- * Параклиникийн тасаг
- * Гал тогоо

Ерөнхий эмчийн 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 76 тоот тушаалаар тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 11 тасагтайгаар тусламж үйлчилгээг үзүүлж байна.

- * Төрөх тасаг
- * Дутуу тээлт эмгэгийг эмчлэх тасаг
- * Жирэмсний эмгэгийг эмчлэх тасаг
- * Төрсний дараах тасаг
- * Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг
- * Мэдээгүйжүүлэг нэгдсэн мэс заслын тасаг
- * Эрчимт эмчилгээний тасаг
- * Эмэгтэйчүүдийн тасаг
- * Нярай н тасаг
- * Бүгд 240 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ТАСГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тасгууд	Орны тоо	Харилцах утас
Төрөх тасаг	50	70111421
Төрсний дараах тасаг		70111422
Дутуу тээлт эмгэгийг эмчлэх тасаг	50	70111425
Эмэгтэйчүүдийн тасаг	65	70111428
Жирэмсний эмгэгийг эмчлэх тасаг	65	70111419
Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг	-	70111427
Мэдээгүйжүүлэг нэгдсэн мэс заслын тасаг	-	70111431
Эрчимт эмчилгээний тасаг	10	70111424
Нярайн тасаг	90	70111423
Бүгд	240	

АМАРЖИХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- * Төрсөн эхийг эсэн мэнд амаржуулах
- * Эрсдэл өндөртэй жирэмсэн эхийг эмчлэх
- * Нярайн асаргаа сувилгаа
- * НҮЭМ-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх
- * Эх, эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох
- * Эмэгтэйчүүдийн өвчнийг эмчлэх
- * Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тусламж
- * Эх эмэгтэйчүүдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн яаралтай тусламжийг чанартай үзүүлэх
- * Нярайн хойшлуулушгүй нэн шаардлагатай тусламж үзүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй

АМАРЖИХ ГАЗРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИРЭЭДҮЙ

- * НҮЭМ-ийн үйлчилгээний хуучин арга барилыг халж, шинэлэг хэлбэр, стандартыг мөрдөх.
- * Гэрийн үйлчилгээг нэвтрүүлж, үйлчилснээр амаржих газрын орны эргэлт ор хоногийг багасгах.
- * Итгэлтэй аюулгүй үйлчилүүлэгч төвтэй чанартай үйлчилгээг эрхэмлэдэг.
- * НҮЭМ-ийн багц тусламж үзүүлэх байгууллагын хөтөлбөртэй байна.
- * Хууль эрх зүйн хэмжээнд эмч эмнэлгийн ажилтны хариуцлага, хандлагыг сайжруулж, ижил төстэй статустай болж эх барих эмэгтэйчүүдийн төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт явуулна.
- * Нийслэл хотын перинатологийн төвийн статустай болж, эх барих эмэгтэйчүүдийн төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт явуулна.

Клиникийн Нэгдүгээр Амаржих Газрын хөгжил, ололт амжилтуудаас

1947- 1967 онд

- * 1947 оны 3-р сард МУИС-ийн Анагаах ухааны факультетийн эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхимийн бааз эмнэлэг болсон.
- * 1949 онд БНМАУ-ын СНЗ-ийн бие даасан төрөх газар болох шийдвэр гарч 1951 онд «Төв төрөх» нэртэй байгуулагдсан.
- * 1967 оны 12 сарын 30-ны 396-р тогтоолоор 1968 оноос «Клиникийн 1-р амаржих газар» болсон.

2000 онд

- * Нийслэлийн хэрэглэгчдийн найдвартай түнш байгууллага
- * Нийслэлийн өмч харилцааны газрын 10-н жилийн ойд зориулсан уралдаанд хотын эмнэлгүүдээс 1-р байр
- * Төгсөлтийн дараах сургалтын алба анх байгуулагдаж сургалт эрхлэх эрхээ авснаар эх барих эмэгтэйчүүдийн эмч мэргэжлээр мэргэшүүлэх резиденсийн сургалтанд анхны элсэлтээ авав.

2001 онд

- * Тэргүүнийн өмч эзэмшигч
- * Эрүүл мэндийг дэмжигч байгууллага»-аар шалгарч 1-р байр
- * Эмэгтэйчүүд болон эх барихын мэс засалд, төрөлтийн үед нугас болон нугасны-эпидураль, эпидураль ерөнхий аргачлалуудыг шинээр нэвтрүүлсэн байна
- * Төрөлтийн үед дан нугасны өвдөлт намдаалтанд опиоид болон хэсгийн мэдээ алдуулах бодисыг бага тунгаар тухайн оноос эхлэн хэрэглэж үр дүнд хүрч ажилласан.

2002 онд

- * Төсөвт санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг эрчимжүүлэх болзолт уралдаанд 1-р байр
- * «Хүүхдийг хөхөөр хооллолт»-ыг дэмжигч байгууллага
- * Дэлхийн 7 хоног сэдэвт уралдаанд 1-р байр
- * Нийгмийн даатгалын шимтгэлээ тогтмол хугацаанд нь төлж өргөмжлөл
- * НЭМГ-аас зохион байгуулсан Хөдөөлгөөн Эрүүл Мэнд, Эрүүл байгаль-Саруул ухаан сэдэвт спорт явган аялалд оролцон тусгай байр диплом
- * Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагчийн үзлэг шалгалтанд Хангалттай үнэлгээ
- * Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйл ажиллагааны стандартын шаардлага хангаж Магадлан итгэмжлэл анх удаа хамгаалж хүртсэн.

2003 онд

- * Бүртгэл, санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтны улсын зөвлөгөөнд 1-р байр

- * Нийслэлийн залуу эмч нарын улсын зөвлөгөөнд амаржих газраас 13 эмчийг бэлтгэн оролцуулж Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлсэнээр эх нярайн эндэгдлийг бууруулах боломж сэдэвт эмчилгээ сургалт эрхэлсэн орлогч дарга Г.Амарбаясгалангийн илтгэл Шилдэг илтгэл
- * Улсын мэргэжлийн хяналтын алба болон Хөдөлмөрийн хуулийн шалгалтанд Хангалттай үнэлгээ.

2004 онд

- * НЭМГ-аас Нийслэл хот байгуулагдсаны 365 жилийг ойг тохиолдуулан зохион байгуулагдсын цэцгийн үзэсгэлэнд Ховор сайхан цэцэг-ээр 1-р байр
- * Сүхбаатар дүүргээс зохион байгуулсан VI спартакиадын анхан шатны аварга шалгаруулах гар бөмбөгийн төрөлд 1-р байр, сагсан бөмбөгийн төрөлд 3-р байр, даамын төрөлд 1-р байр, шатрын төрөлд 1-р байр, багийн нэгдсэн дүнгээр 2-р байр
- * НЭМГ-аас зохион байгуулсан «Хөдөлгөөн эрүүл мэнд» спорт явган аялалд оролцон Шилдэг явган аялагч
- * Сангийн сайдаас Нягтлан бодох бүртгэлийн стандарт нэвтрүүлсэн байгууллага гэрчилгээ
- * Хүүхдийн эмч, мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн хүүхдийн анагаахын тэнхим байгуулагдсаны 50-н жилийн ойгоор Хүндэт өргөмжлөл
- * Сувилахуйн тусламжийн чанарыг сайжруулья-сувилахуйн технологийн шинэчлэл улсын уралдаанд 3-р байр

2005 онд

- * Монголын эрэгтэйчүүдийн холбоо, монголын эмэгтэйчүүдийн холбооноос Энхийн элч буянт үйлсийн эзэд тодров
- * Сүхбаатар дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан ажилгүйдлийг бууруулах аяны ажилд идэвхитэй оролцож Ажил олгогч байгууллагаар шалгарсан
- * Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас Нийслэлийн өмнө дэвшүүлсэн зорилтыг бүтээл үйл ажил хэрэг болгон хэрэгжүүлэх талаар санаачлагатай ажиллах бодитой хувь нэмэр оруулсын үнэлэн 'БҮРЭН ХАНГАЛТТАЙ' үнэлгээ авч Өргөмжлөл хүртэв
- * Нийслэлийн өдрийг тохолдуулах Амаржих газраас Нийслэлийн эрүүл мэндийг дээдлэгч иргэн шалгаруулах болзолт уралдаанд шалгарсан
- * Нийслэлийн засаг даргын нэрэмжит Хангарьд одон медалийг эрүүл мэндийн салбараас анх удаа эх баригч Б.Ичинхорлоо шалгарсан.

2006 онд

- * ЭМЯ ны зүгээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үйл ажиллагааны стандартын шаардлагыг хангасныг үнэлэж эмчилгээ үйлчилгээний магадлан итгэмжлэлээр
- * Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медалиар 4 хүн шагнагдав
- * КНАГ анх удаа байгууллагаа интернет сүлжээнд холбож байнгын 24 цагийн интернетэд холбогдож компьютеруудаа нэмэгдүүлэв
- * Улаанбаатарын хотын 1 сая дахь иргэдийг хүлээн авч эх барьж амаржуулав.

2007 онд

- * КНАГ-ын 80 жилийг угтан «ЭХ НЯЛХСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА» сэдэвт Эрдэм шинжилгээ онол практикийн бага хурал зохион байгуулж бүх төрөх, эрүүл мэндийн нэгдэл, ЭМГ, хөдөөгийн эмч нарыг оролцуулав.
- * КНАГ-ын 80 жилийн үйл ажиллагааны нээлт болгож «Хүн төрүүлсэн эх танд баярлалаа» нэртэй эстрадын тоглолт хийж олны таашаал хүртэв
- * КНАГ дахин шинэ АУ-ны эрдэмтэнтэй болов /АУ-ы доктор Г.Баясгалан/



2008 онд

- * НЭМГ-аас зохион байгуулсан Хөдөөлгөөн Эрүүл Мэнд, Эрүүл орчин –Эрүүл хүнс сэдэвт спорт явган аялалд оролцон тусгай байр диплом
- * Их эмч М.Энхтуяа Алтан гадас одонгоор шагнагдав
- * 2008 онд тус амаржих газар үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойгоо тэмдэглэн олон үйл ажиллагааг үр дүнтэй явуулсан байна
- * Байгууллагын тоног төхөөрөмжийн шинэчлэл ихээр хийгдэж 15 гаруй тоног төхөөрөмжийг шинэчлэв
- * ТДСА нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш нийт 113 дахь резидент эмчийг төгсгөв.



2009 – 2012 онд

- * 2008-2009 онд ЭМЯ, НҮБ-ХАС аас амаржих газарт «Эх нялхаст ээлтэй загвар төрөх» ийн төсөл хэрэгжиж 247 сая гаруй төгрөгний эд материал, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн
- * 2010 оноос Эрдэм шинжилгээ, сургалт гадаад харилцааны алба болон өргөжиж эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резиденсын сургалтыг 1.5 жилээр явуулж нийтдээ 130 орчим эмч мэргэжил олоод байгаагаас гадна дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг тогтмол явуулж байна
- * 2010 онд манай амаржих газрын барилгад их засвар хийгдэж төсөв, хүний нөөц нэмэгдэж тасаг нэгжийн зохион байгуулалтыг шинэчилж хүлээн авах болон хагалгааны нэдсэн тасгийг зохион байгуулсан.
- * 2010-2012 оны хооронд Нэгдүгээр Амаржих Газар дахин 4 эрдэмтэнтэй болж Ч.Мядаг, Т.Одбайгаль, А.Дүүрэнбилэг, С.Мөнхзул нар эмч АУ-ны докторын эрдмийн зэрэг хамгаалав.
- * Эмэгтэйчүүдийн тасгийн хамт олон Монголд анхных болох эмчилгээний шинэ арга технологийг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна / умайн гадуурх жирэмснийг метатрексатаар эмчлэх, шээс задгайрах эмгэгийн үед TVT-О хэрэглэх арга, дурангийн мэс засал гэх аргыг /.
- * ЭМЯ, GTZ –ийн тусламжаар Кольпоскопийн аппараттай болсон нь

эмэгтэйчүүдийн тасагт оношлогооны үйл ажиллагааг сайжруулах түлхэц болсон

- * Төрөлтийн үед дан нугасны өвдөлт намдаалтанд опиойд болон хэсгийн мэдээ алдуулах бодисыг бага тунгаар 2001 оноос эхлэн хэрэглэж үр дүнд хүрч, нийт төрөлтийн 15-16%-д хэрэглэж үр дүнтэй төрөлтийн өвдөлт намдаалт хийж байна
- * Эмэгтэйчүүдийн тасагт сүүлийн үеийн дэвшилтэт арга болох умайн гадуурх жирэмсэний эмгэгийг мэс заслын бус аргаар метатрексатаар эмчлэх аргыг практикт нэвтрүүлж үр дүнтэй ажиллаж улмаар эмчилгээний стандартад бүртгүүлэх шатандаа явж байна. Эмэгтэйчүүдийн тасагт умайн гадуурхи жирэмслэлт оношоор хэвтсэн 80 гаруй эмэгтэйд метатрексат эмчилгээ хийж нөхөн үржихүйн эрхтэн хадгалах үр дүнтэй арга болох нь батлагдаж байна. Цаашид умайн гадуурх жирэмсний үед үрийн хоолойд зүслэг хийж үлдээх аргыг нэвтрүүлэх шатандаа явагдаж байна.
- * Дурангийн 6 сарын сургалтанд 4 эмч сургагдаж Францын Allier хотын Клермон-Ферранд АУИС-н эмнэлэг, Дурангийн олон улсын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улмаар манай эмнэлэгт иж бүрэн дурангийн аппарат суурилуулаж дурангийн мэс заслыг 2009 оноос эхлэн амжилттай хийж байна. /оношлогооны дуран, умайн гадуурх жирэмсний үеийн мэс засал, наалдац салгах мэс засал г.м. мэс заслыг дурангаар хийж байна. Франц улсын хөрөнгө оруулалтаар дурангийн иж бүрэн мэс заслын багаж тоног төхөөрөмжөөр хангагдаад ажиллаж байна
- * Дурангийн мэс заслын сургалтын төв үүсгэн байгуулаад үйл ажиллагаанд орж эхлээд байна /төвд хот хөдөөгийн байгууллагуудын дурангийн мэс засалд суралцах сонирхолтой эмч нарыг сургах боломжтой боллоо/.
- * «Цахим эмнэлэг» төсөл хэрэгжиж байгаатай холбоотойгоор «STS» ХХК-тай хамтран «Wireless» технологээр интернетийн дотоод сүлжээг бүх компьютеруудыг холбосон.
- * Мэдээ мэдээллээ байгууллагынхаа amarjikh1@ubhealth.mn web site даа байрлуулж мөн НЭМГ-ын мэдээллийн санд нэгтгэсэн байдлаар байрлуулж олон нийтэд мэдээллээ нээлттэй хүргэж байна
- * 2011 онд Нэгдүгээр Амаржих Газрын өргөтгөлийн 150 ортой шинэ барилгын шав тавих ёслол болсноос хойш эдүүгээ 2012 оны 12 сард ашиглалтанд орох эх нярайн тусламжийг хангахуйц орчин үеийн эмнэлэг сүндэрлэж байна.



КНАГ – ын Шинэ өргөтгөл – 2012 он

КЛИНИКИЙН НЭГДҮГЭЭР АМАРЖИХ ГАЗРЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ТОВЧ АМЖИЛТЫН ХӨМРӨГӨӨС

1. 2005 оны 5 сард Францын Клермон - Ферранд -н АУИС-н эмнэлэгийн эмч Николас Бурдел, Ян Ланглет, Даниел Девин нар тус эмнэлэгт ирж дурангийн мэс заслын талаарх анхны мэдэгдэхүүн өгөх сургалт зохион байгуулсаар дурангийн мэс засал хөгжих эхлэл болсон
2. 2005 оноос Францын АРАУ төсөлтэй хамтран дурангийн мэс заслыг хөгжүүлэхээр ажиллаж эхэлсэн.
3. 2005-2006 онд тус Амаржих Газрын их эмч Д.Өнөржаргал эмч Францын засгийн газрын тэтгэлээр дурангийн мэс заслын чиглэлээр суралцан дурангийн мэс заслын мэргэжил эзэмшсэн
4. 2009 оны 6-р сард Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг анх удаа хийж эхэлсэн бөгөөд АНХНЫ ДУРАНГИЙН МЭС ЗАСЛЫГ Австралийн Кибеле багийн эмч Ким Жансен болон Кибеле багийнхантай хамт хийсэн
5. 2009 онд Францын Allier мужийн КЛЕРМОН-ФЕРРАНД хотын АУИС-н эмнэлэг, ДУРАНГИЙН ОЛОН УЛСЫН ТӨВТЭЙ хамтран ажиллах гэрээ байгуулж дурангийн мэс заслын багийг багаар Франц улсад сургаж амаржих газар дурангийн мэс заслыг амжилттай хийж байна.
6. 2009 онд БУРИАД УЛСЫН ПЕРИНАТАЛЬ ТӨВ, Буриадын Их сургууль болон Клиникийн Нэгдүгээр Амаржих Газрын хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулан 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Улан үд хотод нийт 5 удаагийн баг 21 хоногийн туршлага солилцох семинар, бага хурал зохион байгуулан оролцож мөн 2 удаагийн Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэн оролцож Оросын талаас ч мөн манай Амаржих газар 2 удаагийн сургалт, хуралд оролцов.
7. 2009 онд Английн «Birthlink International» олон улсын байгууллагатай хамтран ажиллах, туршлага судлах, сургалт явуулах гэрээ байгуулснаас хойш 3 жил хамтран ажиллаж сувилахуйн болон эх баригч нарын ажлын байран дахь сургалтыг амжилттай хэрэгжүүлж, мэргэжилтэний үр чадвар сайржирч байна.
8. 2009 оноос эхлэн өнөөдрийг хүртэл дурангийн мэс заслаар умайн хавдар, өндгөвчний уйланхай, үргүйдлийн эмчилгээ хийж оношлогооны дурангийн мэс засал бүхий нийт 300 орчим дурангийн мэс заслыг амжилттай хийж хүндрэлгүй ажиллав.



9. 2010 оны 3-р сард Францын олон улсын дурангийн төвтэй хамтран «ONLINE» хэлбэрээр хэлэлцэж умайн гаднах жирэмснийг дурангаар эмчлэх мэс заслыг анх удаа амжилттай хийлээ.
10. Франц улсын Олон улсын дурангийн төв дээр 2011 онд эх барих эмэгтэйчүүдийн Т.Ариунцэцэг, Б.Дашдэмбэрэл, мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний Н.Баярцогт эмч нар 6 сарын хугацаанд дурангийн мэс заслын чиглэлээр суралцуулж дурангийн мэс заслын анхны багийг бэлтгэн сургав.
11. 2011 онд Монгол улсын хэмжээнд анх удаа ДЭМБын дэмжлэгтэйгээр 10 000 USD - ын санхүүжилтээр ДУРАНГИЙН СУРГАЛТЫН ТӨВ нээсэн нь дурангийн мэс заслыг хөгжүүлэхэд том алхам болов. Мөн тус төвийг түшиглэн хамтарсан сургалтыг 3 удаа амжилттай зохион байгуулж хот, орон нутгийн эмч, резидент эмч нарыг оролцуулав.



12. 2012 оны 3 сарын 25-аас 04 сарын 09 ний хооронд Эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч Д. Өнөржаргал, эмч Б. Дашдэмбэрэл нар Франц улсын Клермонт-Ферранд хотод зохион байгуулагдсан «Дурангийн мэс заслын шинэ техник технологи, сурган арга зүй» сэдэвт конгресст оролцож, Франц улсад жил бүр 1 эмчийг эмэгтэйчүүдийн чиглэлээр тус төвд сургах гэрээ байгуулав.
13. 2012 онд Франц улсын Allier мужийн ИТХ-ын урилгаар тус Амаржих газрын удирдлага эмч нарын бүрэлдэхүүнтэй 5 хүний баг Франц Улсад айлчилж Монгол улсад дурангийн мэс засал хөгжиж байгааг сурталчлан Хамтран ажиллах 3 жилийн гэрээ байгуулсанаар Олон улсын дурангийн сургалтын төв дээр жил бүр эх барих эмэгтэйчүүдийн, нярайн эмч, эх баригч нарын бүрэлдэхүүнтэй сургахаар тохиролцож гэрээ хийгдэж анхны 3 мэргэжилтэн суралцаад ирлээ.
14. Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг дэлхийн жишигт дүйцэхүйц хөгжүүлэхийн тулд ДЭМБ, ЭМЯ, Төгөлдөр сан, КНАГ, Австралийн дурангийн мэс заслын нийгэмлэгтэй хамтран онол эмнэлзүйн сургалтыг 2012 оны 6 сарын 18-20 хооронд Чингэс зочид буудалд зохион явууллаа. КНАГ Австралийн дурангийн мэс заслын нийгэмлэгтэй хамтран 5 жилийн хугацаатай эмч нарыг Австралид сургах гэрээ хийхээр товллоо.
15. 2011 оны 08 сард Тайван Улсын Тайпэй хотын «INTERNATIONAL HEALTHCARE TRAINING CENTRE» төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 2012 оноос



эхлэн эмч эмнэлгийн ажилчдыг эх барих болон эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, үргүйдэл болон эмнэлгийн удирдлагын чиглэлээр суралцаж туршлагжихаар үзэглэсэний дагуу жилд 3 удаагийн эмч, эмнэлгийн мэргэжилтэний баг 1 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцаж мэргэжил мэдлэгээ дээшлүүлэв. Мөн дараагийн ээлжинд удирдлагын баг, мөн дараагийн баг суралцуулахаар бэлтгэж ажил хангагдаж байна.



16. 2011 онд Швейцарийн «Нярайн түнхний үеийн мултрал, дутуу хөгжлийг эрт оношлох» төслийн хүрээнд нийт төрсөн нярайд эмч нар урьдчилан сэргийлэх оношлогоо хийж эхэлсэн бөгөөд 2012 оноос эхлэн нярай хүүхдэд хийгдэх скрининг шинжилгээний арга болгож нярай бүрийг шинжилгээнд хамруулж төслийн багтай хамтран ажиллаж байна.
17. 2012 онд ОХУ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Эрхүү мужийн Эрүүл мэндийн Яам, Эрхүү мужийн гэр бүлийн эрүүл мэнд, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрдэм шинжилгээний төвийн хамтран зохион байгуулсан «Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэс» сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээ, онол практикийн II-р бага хуралыг 06 сарын 29-30 нд тус Амаржих газрын 3 эмч оролцон илтгэл хэлэлцүүлэв. Мөн цаашид тус төвтэй хамтран ажиллах гэрээ хэлэлцээр бэлтгэгдэж байна.



ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮД СУДЛАЛЫН ТЭНХИМ

1. 1947 оны 9 сард МУИС-ын Хүн эмнэлгийн факультетийн харьяанд Төв больницын төрөх тасгийг түшиглүүлж эх барих эмэгтэйчүүдийн өвчин судлалын тэнхим байгуулагдаж, эрхлэгчээр нь ЗХУ-ын Ленинград хотоос уригдаж ирсэн В.А.Анисимов ажиллаж байжээ. Тэнхим анх зөвхөн тэнхмийн эрхлэгчийн орон тоотой байсан бол эдүгээ 9 багштай 2 ажилтантай хүний нөөцөөр бэхэжсэн юм.
